ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 01 өдөр Дугаар 8/01 Ховд

Хэлэлцэх асуудал, дотоод журам, үйлчлэх
Ажлын албадыг батлах тухай

Аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, дотоод журмыг 2 дугаар хавсралтаар, хуралдаанд үйлчлэх Ажлын албадыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 01 өдөр Дугаар 8/02 Ховд

Тайланд үнэлэлт өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг үндэслэн "аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай" аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвгандийн илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг."Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай" илтгэлд тусгагдсан аймгийн ИТХ-аас 2018 онд дэвшүүлсэн зорилтыг хангаж ажилласныг тэмдэглээд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнд хийсэн дүгнэлт, цаашдын дэвшүүлсэн зорилтыг сайшааж үйл ажиллагааны үр дүнг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

Хоёр. Аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1.Нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэснээр иргэдийн ажлын байрыг хадгалан нэмэгдүүлэх, өрхийн бодит орлогыг өсгөн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийн хүрсэн үр дүнд хяналт үнэлгээ хийж цаашид эрчимжүүлэх арга хэмжээ авах.

2.2.Бүх шатны Хурлын байгууллагуудын хүрсэн ажлын үр дүнг тогтмолжуулан дээшлүүлж орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдвэрлэн хэрэгжүүлж үр дүнг тооцдог тогтолцоог хэвшүүлэх.

2.3.Аймгийн хэмжээнд 2018 оныг жижиг, дунд бизнесийг дэмжиж, төрийн ажил үйлчилгээг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор "Өрхийн болон жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжих жил" болгосонтой

холбогдуулан нутгийн захиргааны байгууллагуудын орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт, хувийн хэвшил, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын түншлэл, иргэдийн оролцоог хангахад бодлогын болон үйл ажиллагааны бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллаж хэрэгжилтийн явц, үр дүнд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авах.

2.4.Бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагуудын бүтээмжийг дээшлүүлэхээр сонгуультан, ажилтнуудын ажлын хүрсэн үр дүнг тогтмолжуулан эрчимжүүлж шинэлэг ажлын санаачилга, мэргэшил, ур чадвар, үр дүн, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх бодиттой ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.

2.5.Сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагаанд үзүүлэх мэргэжил арга зүйн удирдлага, туслалцааг тогтмолжуулан эрчимжүүлж, үр нөлөөг дээшлүүлэх.

2.6.Хууль тогтоомж, Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрийн талаар иргэд, олон нийтэд хүргэх сурталчилгаа, мэдээллийг өргөтгөж хэрэгжилтийг сайжруулан, биелэлтийн үр дүнд тавих хяналт, үнэлгээний ажлыг тогтмолжуулах арга хэмжээ авах.

2.7.Аймаг, сум, багийн түвшинд иргэдэд хандсан хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, мэдээллийг өргөтгөж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэн нийтийн хэв журмыг хангах ажлыг тогтмолжуулан сайжруулах.

2.8.Аймаг, сумын Хурлын байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчдад шинээр хэрэгжиж буй чадахуйн зарчимд суурилсан төрийн албаны шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган сурталчилж, хэлбэрэлтгүй дагаж мөрдөн төрийн алба болон төрийн албан хаагчдыг чадавхжуулах бодлогыг хэрэгжүүлж, ажлын үр дүнгээр хүлээх хариуцлагыг өндөржүүлж ажиллах.

2.9.Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж биелэлтийг тооцож, үр дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулж ажиллах.

Гурав. Сумын ИТХ-ын дарга, багийн ИНХ-ын дарга нарт ЗӨВЛӨХ нь:

1.Хууль тогтоомж, 2019 оноос хэрэгжиж буй төрийн албаны тухай шинэчилсэн хууль, Монгол улсын Засгийн газраас гаргасан төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг чангатган сайжруулах тухай шийдвэрүүд, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан “Хариуцлагатай тунгалаг төр” аймгийн

дэд хөтөлбөрийг өргөнөөр сурталчилж биелэлтийг хангаж, үр дүнг тооцож ажиллах.

2.Нийгмийн хэв журмыг хангах талаар гарсан хууль тогтоомж, эрх бүхий байгууллагуудын шийдвэрийг нийтэд хүргэх мэдээлэл сурталчилгааг өргөтгөж, хэрэгжилтийг ханган гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэдийн оролцоотой үр өгөөжтэй зохион байгуулах арга хэмжээ авах.

3.Орон нутгийн иргэдийн таатай нөхцөлд ажиллаж, ая тухтай амгалан тайван амьдрах бүхий л нөхцөл боломжийг эрэлхийлэн иргэдийн оролцоотой шийдэж үр дүнд хүргэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэн үр дүнг тооцож, тайлагнаж ажиллах.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 01 өдөр Дугаар 8/03 Ховд

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн 2018 оны хэрэгжилтэд үнэлэлт өгөх тухай

Монгол улсын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн "д", 19 дүгээр зүйлийн 19.1, 26 дугаар зүйлийн 26.9 дэх заалтыг үндэслэн "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилт, тайлангийн жилийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлсэн дүн, цаашдын зорилтын тухай" аймгийн Засаг дарга Б.Дүгэржавын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилт, бүтээн байгуулалтын ажлын үр дүнг 60.2 хувийн биелэлттэй буюу "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

Хоёр. Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн биелэлтийг 80.0 хувь буюу "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

Гурав. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2019 оныг "Өрхийн болон жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжих жил" болгон зарласугай.

Дөрөв. Аймаг, сумын Засаг дарга нарт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

4.1.Аймгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн өсөлт, иргэдийн ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх, шинэ технологийг дэмжсэн бүхий л салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний хөрөнгө оруулалтад чиглэсэн хөтөлбөр, төслүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх талаар хувийн хэвшлийн байгууллагуудтай түншлэлтэйгээр ажиллах.

4.2.Төрийн захиргаа болон нийгмийн салбарын байгууллагуудаас иргэд олон нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг эрс дээшлүүлэн, үр дүнд хяналт үнэлгээ хийж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх.

4.3.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт суурилсан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлийн зорилтуудыг хангаж улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд тавих хяналтыг тогтмолжуулж, үр ашгийг дээшлүүлэх.

4.4. 2019 оноос хэрэгжих чадавхын зарчим, үр дүнд суурилсан төрийн албаны шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах.

4.5.Төрийн албан хаагчдын чадавхыг сайжруулах бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, ажлын үр дүнгээр хүлээх хариуцлагыг тооцох тогтолцоог хэвшүүлэх.

4.6.Аймгийн хэмжээнд 2019 оныг “Өрхийн болон жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгосонтой холбогдуулан сум, салбар, байгууллага бүрд хэрэгжих хөрөнгө оруулалт, бүтээлч ажлыг тодорхой төлөвлөн биелэлтийг хангахад салбар дундын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

4.7.Мал аж ахуйн салбарт өвөлжилт хаваржилтыг өнтэй даван туулахад онцгойлон анхаарч өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль цаг уурын учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж, малыг бүх төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллах.

Гурав. Тус тогтоолын биелэлт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны зорилтын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг улирал бүр өссөн дүнгээр тооцож, аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ

ХОВД АЙМГИЙН

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 01 өдөр Дугаар 8/04 Ховд

Аймгийн 2019 оны төсөв батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “б”, 19 дүгээр зүйлийн 19.1, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Аймгийн төсвийн 2018 оны урьдчилсан гүйцэтгэл, 2019 оны төсвийн төслийн тухай” аймгийн Засаг дарга Б.Дүгэржавын илтгэлийг хэлэлцээд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

I	Төсвийн нийт орлого	8117840.0
II	Суурь орлого	8110990.0
1.	Урсгал орлого	8040990.0
1.1.	Татварын орлого	7219550.0
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын тухай[1] хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар	5852000.0
1.1.1.1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	6712000.0
1.1.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-860000.0
1.1.2.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	332500.0
1.1.3	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	455000.0
1.1.4	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	221500.0
1.1.5	Газрын төлбөр	215000.0
1.1.6	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	120250.0
1.1.7	Бусад татвар, төлбөр хураамж	23300.0

1.2	Татварын бус орлого	681440.0
1.2.1	Ногдол ашиг	10000.0
1.2.2	Хүү, торгуулийн орлого	494940.0
1.2.3	Төсөвт байгууллагын өөрийн орлого	70500.0
1.2.4	Төсөвт төвлөрүүлэх бусад орлого	246000.0
2.	Хөрөнгийн орлого	70000.0
3.	Нийт орлогод орох бусад орлого	6850.0
3.1	ТЗШ-гээр санхүүжих төсвийн байгууллагын өөрийн орлого	6850.0

Хоёр. Аймгийн төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар батална.

/мянган төгрөгөөр/

2.1.	**Засаг дарга**	**77350.0**
1	Аймгийн ЗДТГ	17000.0
2	Орон нутгийн өмчийн газар	4000.0
3	Асрамжийн газар	1000.0
4	Ойн анги	4000.0
5	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1000.0
8	Орон нутгийг судлах Музей	6000.0
9	Номын сан	2500.0
10	ХДТ	25000.0
11	Биеийн тамир спортын газар	10000.0
12	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	6850.0

Гурав. Аймгийн төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай.

/мянган төгрөгөөр/

д/д	Төсвийн захирагч	Дүн
3.1.	**Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга**	**483833.8**
	Урсгал зардал:	483833.8
	Хөрөнгийн зардал:	0.0
	Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга	**483833.8**
	Үндсэн үйл ажиллагаа	331428.8
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	120000.0
	Мэдээлэл сурталчилгааны зардал	24 00.0
	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	5000.0
	Биеийн тамирын арга хэмжээ	405.0
	ИТХ-д суудалтай намд олгох дэмжлэг	18600.0
	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	6000.0
3.2.	**Засаг дарга**	**6675190.0**
	Урсгал зардал:	5612690.0
	Хөрөнгийн зардал:	1062500.0

Аймгийн Засаг даргын тамгын газар	**1782646.8**
Урсгал зардал	1139925.3
Үндсэн үйл ажиллагаа	230000.0
Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	10800.0
Мэдээлэл сурталчилгааны зардал	18000.0
Харуул хамгаалалтын зардал	2000.0
Биеийн тамирын арга хэмжээ	7000.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	364921.5
Нөөц хөрөнгө	10000.0
Баяр наадам зохион байгуулах	
Санхүүгийн хяналт, аудитын алба	**128631.7**
Үндсэн үйл ажиллагаа	126631.7
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2000.0
Орон нутгийн өмчийн газар	**150747.3**
Үндсэн үйл ажиллагаа	148747.3
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2000.0
Байгаль орчин аялал жуулчлалын газар	**413394.3**
Үндсэн үйл ажиллагаа	401694.1
Мэдээлэл сурталчилгааны зардал	430.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	11270.2
Ойн анги	**50820.0**
Үндсэн үйл ажиллагаа	44720.0
Харуул хамгаалалтын зардал	5500.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	600.0
Халамжийн сан	**154880.9**
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	34880.9
Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж	120000.0
Аймгийн асрамжийн газар	**248864.5**
Үндсэн үйл ажиллагаа	237344.5
Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	11520.0
Засаг дарга шууд	**878321.9**
Ахмад настны хөгжил хамгаалал	
Жолоочийн ХДС-д олгох шилжүүлэг	62798.6
Хотын нийтийн хүн тээврийн татаас	42500.0
Авто тээврийн хяналтын постын зардал	45000.0
Гэр хорооллын усны үнийн хөнгөлөлт	30000.0
Байгаль хамгаалах сан	55320.0
МЭУСАХ-ий зардал	620488.0
	22215.3

Номын сан	**213623.6**
Үндсэн үйл ажиллагаа	213123.6
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	500.0
Музей	**166515.8**
Үндсэн үйл ажиллагаа	166015.8
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	500.0
Хөгжим дармын театр	**761745.7**
Үндсэн үйл ажиллагаа	691832.5
Уран бүтээл хийх	43386.8
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	26526.4
Биеийн тамир спортын газар	**486496.6**
Үндсэн үйл ажиллагаа	442597.1
Биеийн тамирын уралдаан тэмцээн	34500.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	9399.5
Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтэс /тогтмол зардал/	**137829.1**
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /тогтмол зардал/	**38171.8**
Хөрөнгийн зардал	**1062500.0**
Замын сангийн засвар, арчилгаа	382500.0
ОН-ийн хөрөнгө оруулалт	680000.0

Дөрөв. Аймгийн 2019 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 7159023.8 мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Аймгийн замын сангийн их засварын зардлын хэмжээг 382500.0 мянган төгрөгөөр баталсугай.

Зургаа. Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Дүн
6.1.	Алтай	494997.8
6.2.	Булган	613093.1
6.3.	Буянт	417361.5
6.4	Дарви	419853.9
6.5	Дөргөн	442875.9
6.6	Дуут	426190.4
6.7	Зэрэг	585441.6
6.8	Манхан	714761.0